



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 14

Номгон

Г 7

Үндсэн хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2.2, 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хүрээмжарал, Богд сумын Эрүүл мэндийн төв, Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хөрөнгөд бүртгэлтэй суудлын автомашинуудыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Автомашины нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 11⁰⁰ цагт аймгийн Орон нутгийн өмчийн газрын 114 тоот өрөөнд зохион байгуулж орлогыг Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх;


2.2 Худалсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайландаа тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 04 дүгээр сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанад ирүүлэх.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 08 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 6, 8 дугаар мөрүүдэд заасан хөрөнгийг шилжүүлэх тухай заалтыг хүчингүй болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.





 Аймгийн Иргэдийн төлөөлгөчдийн хурлын
 Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дугээр сарын
 31-ний өдрийн 14 дугээр тогтоолын хавсралт

**ХУРЭЭМАРАЛ, БОГД СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ,
 БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ИРГЭДИЙН
 ТӨЛӨӨЛГӨЧДИЙН ХУРЛЫН ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн серийн дугаар	Ашиглалтад орсон отноо	Нийт үнэ	Элэгдэл	Үлдэх өртөг	Дудлагаар худалдах доод үнэ	Тайлбар
1	Хүрээмарал	ЭМТ	Автомашин УАЗ-315122 БНА82-02	УАЗ-315122	БНА 82-02	10.12.30	14000000	14000000	0	1000,0	2008 онд ашиглалтад орсон 14,0 сая төгрөгийн үнэтэй өртөгөө 100% нөхсөн
2	Богд сум	ЭМТ	Автомашин УАЗ-220692-033 БНХ25-87 033	УАЗ-220692-033	БНХ 25-87	11.08.03	18500000	18500000	0	1000,0	2011 онд ашиглалтад орсон 18,5 сая төгрөгийн үнэтэй өртөгөө 100% нөхсөн
3	Буучагаан	ЗДТГ	Суудлын автомашин	Ланд круйзер-100	БНХ 77-03	14.12.31	28000000	19055555,2	89444444,8	8945,0	2014 онд ашиглалтад орсон 28,0 сая төгрөгийн үнэтэй 8,9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй
4	Буучагаан	ИТХ	Япон суудлын автомашин	CRV HONDA	БНА 86-13	09.12.25	11000000	11000000	0	500,0	2009 онд ашиглалтад орсон 11,0 сая төгрөгийн үнэтэй өртөгөө 100% нөхсөн